



2019 он 4 сар 27 өдөр

Дугаар 131/01

Улаанбаатар хот

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2019 оны 4 сарын 27-ны өдөр

Хурлын байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингаравын 14-р гудамж, Зайсан Хилл цогцолборын хурлын танхимд

Хурал эхэлсэн цаг: 09 цаг 30 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 19,948,558 ширхэг буюу 79.79%

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье. Ард Даатгал ХК олон нийтэд нээлттэй, үйл ажиллагаа, санхүүгийн хувьд ил тод компани болохын хувьд Төлөөлөн Удирдах зөвлөлийн нийт гишүүд санхүү, үйл ажиллагааны тайлангаа тавих болно. Асуудал хэлэлцэхээс өмнө Тооллогын комиссын зүгээс өнөөдрийн хурлын ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Компанийн тухай хуулийн 69.1 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн саналын эрх бүхий нийт хувьцааны 19,948,558 ширхэг буюу 79.79%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хурлын ирц болон тооллогын комисстой холбоотой асуулт байхгүй бол хурлаа эхэлье. Хурлын дэгийг Гүйцэтгэх захирал Г.Цогбадрахыг танилцуулна уу хэмээн урья.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хэлэлцэх асуудлын дагуу Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах танилцуулгаа эхлүүлнэ үү.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: 2018 он Ард Даатгал ХК-ийн хувьд түүхэн амжилт гаргасан жил байлаа. Манай компани 2017 оны цэвэр ашгийн 50 хувь буюу 562 сая төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ хуваарилсан. 2018 оны 4 сард болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Ард Даатгалыг нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гарсан. Үүнтэй холбогдуулан нээлттэй хувьцаат компанийн зарчимтай нийцүүлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг долоогоос есөн гишүүнтэй болгон өөрчилсөн. Ийнхүү Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг, Ард Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Золбоо нарыг ердийн гишүүнээр, Улаанбаатар дахь Америк сургуулийн зөвлөх багш З.Ариун, NTV ТВ-ийн сэтгүүлч, хөтлөгч Б.Болорчимэг нарыг хараат бус гишүүнээр томилсон. Мөн 2018 оны 6 сарын 30-ны дотор ПРО хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоор зорьж ажилласан бөгөөд 2018 оны 8 сарын 29-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл гарч, 9 сарын 17-ноос 26-ны өдрийн хооронд анхдагч зах зээлийн арилжаа явагдсан. Хувьцааны захиалга 32.7 хувиар давж биелсэн ба компани маань хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй даатгалын компани болсон билээ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 1-нд зохион байгуулж, дүрмийн санг нэмэгдүүлэх, компанийн дүрмийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэн баталсан. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2018 онд таван удаа хуралдсан байна. Ингээд ТУЗ-ийн гишүүн Б.Золбоог Ард Даатгал ХК-ийн 2018 оны санхүүгийн үзүүлэлтийг танилцуулна уу хэмээн тайзнаа урьж байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо Ард Даатгал ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Энэ өдрийн мэндийг хүргэе. 2018 оны хувьд нийт хураамжийн орлого 26 хувиар, цэвэр хураамжийн орлого 39 хувиар, орлогод тооцсон хураамж 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2017 онд зардал 3.8 тэрбум байсан бол 2018 онд 5 тэрбум болж өссөн. Цэвэр ашиг 2018 онд 1.2 тэрбумаар буюу 12 хувиар өссөн байна.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах хувьцааны арилжааны тухай мэдээллийг танилцуулав.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: 2018 оны 9 сарын 27-нд анхдагч арилжаа өндөрлөж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос арилжааг хүчин төгөлдөрт тооцсоноор 2018 оны 10 сарын 2-ноос эхлэн хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаж эхэлсэн. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар хаалтын ханш 770 төгрөг байсан бөгөөд Ард Даатгал ХК-ийн хувьцаа нь хөрөнгийн зах зээлд өндөр эрэлттэй бүтээгдэхүүн болж чадсан билээ.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг Даатгалын зах зээлийн тухай танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: Ард Даатгал ХК нь Монголын даатгалын компаниудаас нийт хөрөнгөөр тавдугаар байранд, зах зээлд эзлэх хувиараа наймдугаар байранд тус тус жагсаж байна. Хамгийн чухал үзүүлэлт болох цэвэр ашгийн хувьд 2018 онд 1.3 тэрбум байсан ба энэ нь зах зээлд дөрөвдүгээр байранд орох үзүүлэлт юм.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Үйл ажиллагаа, санхүүгийн тайлан болон хувьцааны тухай мэдээллийг ТУЗ-ийн гишүүд маань танилцууллаа. Үүнтэй холбоотой хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Б.Жаргалсайхан: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэхүү арга хэмжээг зохион байгуулж буй Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Даатгал ХК-ийн хамт олондоо амжилт хүсье. Г.Цогбадрах захирлаас асууя. Манай Ард Даатгал ХК 1,700 гаруй хувьцаа эзэмшигчтэй болсон

гэлээ. Эдгээр хувьцаа эзэмшигч бүртээ даатгалын үйлчилгээгээ үзүүлж чадаж байна уу? Миний хувьд зөвхөн жолоочийн албан журмын даатгалд даатгуулсан. Үүнээс гадна тээврийн хэрэгслийн иж-бүрэн даатгал, хөрөнгийн даатгал авах хүсэлтэй байна. Гэвч надад энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирдэггүй. Иймээс 1,700 гаруй хувьцаа эзэмшигчиддээ хүрч ажилламаар байна.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Монгол Улсал жолоочийн хариуцлагын, тээврийн хэрэгслийн, хөрөнгийн, эрүүл мэндийн даатгал зах зээлийн 80-85 орчим хувийг эзэлдэг. Үүнээс хамгийн их хувийг жолоочийн хариуцлагын даатгал эзэлдэг. Хувьцаа эзэмшигч Б. Жаргалсайханы хэлдэг үнэн. Манай хувьцаа эзэмшигчид эд хөрөнгөө компанидаа даатгуулах нь зүйтэй. Оны эхэнд хувьцаа эзэмшигчиддээ ардкoйн тарааж эхэлсэн. Мөн жолоочийн хариуцлагаас бусад төрлийн даатгалд даатгуулсан харилцагч нартаа даатгалын үнийн дүнгээс хамаарч койноор урамшуулал олгож байна. Энэ оны 2-р улиралдаа багтаан Ард Апп дээр даатгалын цэсийг суулгаж өгөхөөр ажиллаж байна. Цаашид энэ асуудал дээр илүү анхаарч, та бүхэндээ хүрч ажиллахыг хичээх болно.

Хурлын дарга Ч.Ганхуяг: ТУЗ-ийн гишүүдээс нэмж тайлбар хийх үү?

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Миний бие Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн турш ажиллаж байна. Энэ хугацаанд компани маань нэлээдгүй урт замыг туулж өнөөгийн түвшинд хүрсэн гэдгийг хэлэхэд таатай байна. Ард Даатгал, Ард Санхүүгийн Нэгдэл компаниудын удирдлагын багийн хүчээр Ард Даатгал компани хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож, 5.25 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж чадсан. Миний бие хэд хэдэн төрийн байгууллагад ТУЗ-ийн гишүүн болон даргаар ажилладаг. Үүнээс засаглалын болон үйл ажиллагааны хувьд хариуцлагатай, эрүүл компани ховор байдаг. Ийм үлгэр жишээ компани бол Ард Даатгал ХК юм гэдгийг та бүхэнд хэлмээр байна. Аливаа компани бизнесийн үр ашиг, өгөөжийн төлөө ажиллах ёстой. Үүний зэрэгцээ засаглал маш сайн байх ёстой. Тиймээс өнөөдөр хуран цугласан хувьцаа эзэмшигч та бүхнийхээ өмнө Төлөөлөн Удирдах Зөвлөл бизнесийн үр ашгаа дээшлүүлэх, борлуулалтын төрлөө нэмэх, зах зээлд тэргүүлэх зэрэг хариуцлагыг үүрч ажилладаг гэдгээ дуулгая. Та бүхнийг мөн компанийнхаа борлуулалт, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриалж байна.

Ийнхүү 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудлыг хааж, дараагийн асуудалд оров.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлын хэлэлцүүлэг эхэлж, ТУЗ-ийн гишүүн Б.Болорчимэг Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийг танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Б.Болорчимэг: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож буйд талархал илэрхийлье. Миний бие NTV ТВ-д сэтгүүлч, хөтлөгчөөр ажилладаг. 2018 оноос хойш Ард Даатгал ХК-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийг танилцуулъя.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч:

Ч.Ганхуяг-Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал;

О.Одбаяр-Эрдэнэс Монгол ХХК-ийн Бизнес хөгжил эрхэлсэн дэд захирал;

Ч.Ганзориг-Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал;

Г.Цогбадрах-Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал;

Б.Золбоо-Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал;

С.Оргил-Мост Финтек ХХК-ийн Гүйцэтгэх захирал;

Б.Лхагвадорж-БиДиСек ХК-ийн Тэргүүн дэд захирал.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч:

З.Ариун-Улаанбаатар дахь Америк сургуулийн зөвлөх багш;

Х.Индра-Хувиараа бизнес эрхлэгч

Б.Болорчимэг-NTV ТВ-ийн сэтгүүлч, хөтлөгч;

И.Сэр-Од-Монголын Бизнес Мэдээллийн Баазийн Гүйцэтгэх захирал.

Хурлын дарга Ч.Ганхуяг-Төлөөлөн Удирдах Зөвлөл нь бүрэн эрхийнхээ хугацаанд хувьцаа эзэмшигч та бүхний төлөөлөл болж компанийг удирдах, үйл ажиллагааг чиглүүлэх, Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, тайланг нь хүлээн авах үүрэгтэй байгууллага юм. Бид 1,718 хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарынхаа өмнөөс хариуцлагатай шийдвэр гарган ажиллах болно. Компанийн дүрэмд Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна гэж заасан. Та бүхэн саналын хуудас болон цахимаар саналаа өгөх боломжтой. Санал хураалт эхлэхээс өмнө ТУЗ-д шинээр нэр дэвшигчид өөрсдийгөө танилцуулна уу?

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч И.Сэр-од: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Маш их өсөх ирээдүйтэй Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаадаа баяртай байна. 2014 оноос хойш Монголын Бизнес Мэдээллийн Бааз Төрийн бус байгууллагын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдвол гаднаас хөрөнгө оруулалт татах, гадаад харилцааг сайжруулах тал дээр идэвхтэй ажиллах болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Х.Индра: Намайг Хурцын Индра гэдэг. Миний бие уул уурхайн салбарт 15 гаруй жил ажилласан. Энержи Ресурс ХХК-д 10 жил, Мон Энко ХХК-д 5 жилийн турш ажилласан. Энэ хугацаанд хэд хэдэн том төсөл дээр ажиллаж байсан ба үүнээс дурьдвал Энержи Ресурс ХХК-ийн ХонгКонгийн хөрөнгийн бирж дээр IPO хийх үйл явцыг хариуцан ажиллаж байсан туршлагатай.

Хурлын дарга Ч.Ганхуяг: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчиддээ баярлалаа. Манай компанин ТУЗ-д 6 ердийн, 3 хараат бус нийт 9 гишүүнийг сонгох ёстой. Нэр дэвшигчидтэй холбоотой асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Б.Ган-Эрдэнэ: Ч.Ганхуяг, О.Одбаяр захирал нараас асууя. Хэд хэдэн компанид ТУЗ-ийн гишүүн болон даргаар ажиллах хэр их ачаалалтай байдаг вэ?

Хурлын дарга Ч.Ганхуяг: Мэдээж маш их ачаалалтай байдаг. Сүүлийн 14 хоног хэд хэдэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцлоо. Гэвч ийм олон хүний итгэлийг хүлээн ажиллаж байгаагийн хувьд ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх ёстой.

Хувьцаа эзэмшигч Д.Мөнхтөр: Энд хуран цугласан та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Заалнаас ТУЗ-д нэр дэвших боломжтой юу?

Ард Даатгал ХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд: Заалнаас нэр дэвших боломжгүй. Компанийн тухай хуулийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хурлаас өмнө хувьцаа эзэмшигчидэдээ хүргүүлэх ёстой байдаг. Хувьцаа эзэмшигч нар ТУЗ-д нэр дэвших боломжтой ба бичгээр хүсэлт ирүүлэх ёстой. Мөн манай компани хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын сониноор зарлуулсан ба 2019 оны 02 сарын 21-ны өдрөөс 2019 оны 03 сарын 05 хүртэл нэр дэвшигчдийн материалыг хүлээн авсан.

Хувьцаа эзэмшигч Д.Ганбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТУЗ-ийн гишүүн О.Одбаяраас асуух асуулт байна. Миний бие Эрдэнэс Монгол ХХК, Шивээ Овоо ХК-д хувьцаа эзэмшээд 5 жил болж байна. Харамсалтай нь эдгээр компанийн хувьцаа уналттай байгаа. Та Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний хувьд ямар үүрэгтэй ажилладаг вэ?

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Төлөөлөн Удирдах Зөвлөл хамтын шийдвэр гаргадаг байгууллага. Миний бие Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг үүсгэн байгуулалцсан хүмүүсийн нэг. Иймээс Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигч болохын хувьд Ард Даатгал ХК-ийн ердийн гишүүнд нэр дэвшиж байна.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс нэмэлт асуулт байхгүй бол санал хураалтаа эхлүүлэе. Санал хураалтын заавар бичлэгийг танилцуулъя.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгоно. Та бүхэн интернетэд холбогдон vote.ard.mn хаягаар нэвтэрнэ үү. Нэвтэрч орсны дараа дөрвөн компанийн цэс харагдана. Үүнээс Ард Даатгал компанийг сонгон, бүртгэлийн кодоо ашиглан нэвтэрч орно. Бүртгэлийн код нь та бүхний мандатны ард бичигдсэн 8 оронтой дахин давтагдахгүй тоо юм. Ийнхүү бүртгэлийн кодоо ашиглан нэвтрэн орсны дараа хэлэлцэх асуудлуудад саналаа өгөх боломжтой. Хэрэв интернетэд холбогдох боломжгүй бол цаасаар санал өгөх боломжтой.

Ийнхүү хэлэлцэх асуудлыг хаан, санал хураалт явуулахаар тогтов. Хувьцаа эзэмшигчид хэлэлцэх асуудалд багтсан 2 асуудлаар өөрсдийн саналыг өгөв.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссын даргыг санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн тайзнаа урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг танилцуулъя.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүнг танилцуулах нь.

Ч. ГАЙДУЯГ